

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2021-2024 он)

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА				ХАРИУЦАХ ЭЗЭН
				2021	2022	2023	2024	
1. Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх								
1.1	Эмнэлгийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу ажлын байрны хэрэгцээг тодорхойлон, хүний нөөц бүрдүүлэлтийг үе шаттай дотоод болон гадаад нөөцөөс бүрдүүлэх	Хүний нөөцийн хангалтыг үе шаттайгаар бүрэн хангасан байна.	Эмч эмнэлгийн мэргэжилтний хангагдсан тоо				+	Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сул, эзгүй ажлын байрыг нөхөхөөр холбогдох зар мэдээг тогтмол оруулж, хүний нөөцийг дотоод болон гадаад нөөцөөс бүрдүүлэн байгууллагын бүтэц, стандартын дагуу хангалтын хувь 97,7%-тай ажиллаж байна.
1.2	Нээлттэй ажлын байранд ажилтныг хүний нөөцийг сонгон шалгаруулах журмын дагуу ил тод сонгон шалгаруулж, хүний нөөцийг бүрдүүлэх	Хүний нөөцийн ил тод байдал хангагдсаны байна. Чадварлаг ажилтнаар хүний нөөцийг бүрдүүлсэн байна.	Нээлттэй сонгон шалгаруулалтын зарлалын тоо Шинээр авсан ажилтны тоо				+	Zangia.mn болон цахим байдлаар, нээлттэй өдөрлөгүүдэд ажлын байрын зарыг байршуулан шинэ ажилтныг сонгон шалгаруулах журмын дагуу чиглүүлэн сурган авдаг. Удирдах албан тушаалтныг төвийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны тогтоолоор батлагдсан журмын дагуу 4 албаны даргыг томилон ажилсан.
1.3	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны дүн шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах	Эмч, эмнэлгийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт шинэчлэгдсэн байна.	Шинэчлэн боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын тоо				+	Ажлын байрны уялдаа холбоо, хамаарал, мөн ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, чанар аюулгүй байдлын үйл ажиллагааны оролцоог тодорхой тусган эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, тасаг албадын дарга нарын албан тушаалын тодорхойлолтод 7-8 зорилтыг, бусад байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах туслан гүйцэтгэх албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод 4 зорилтыг тусган бусад сайжруулалтыг хийн шинэчлэн боловсруулж, Нийт 52 албан тушаалын тодорхойлолт 3 дугаар улиралд батлуулсан.

1.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажилласан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны холбогдох хуулийн дагуу зохистой харьцаа хувь				+	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн “144.2.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 4%-аас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна” заалтын дагуу төвийн батлагдсан орон тооны 4%-ийн ханган ажиллаж байгаа.
-----	--	---	--	--	--	--	---	---

2. Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангаж, чадавхийг бэхжүүлэх

2.1	Удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн үйл ажиллагааг хэвийн хангах албан тушаалтнуудыг олон улсын болон дотоодын байгууллагын зохион байгуулж байгаа хувь хүний хөгжил, ёс зүй, манлайлал сэдэвт сургалтад хамруулах	Байгууллагын соёл тогтворжиж, хувь хүний ёс зүй дээшилнэ.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо				+	Ёс зүйн хороо Нарны шаргал тусгал НҮТББтэй 6 сарын 15ны өдөр хамтран зохион байгуулсан “Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх, ёс зүйн шинэ ойлголт” сэдвийн /1,0 кредит/ сургалтад 64 эмч, эмнэлгийн ажилтан, резидент эмч нарыг хамруулсан. “Ёс зүйг чадавхжуулах нь” уриан дор “Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа, хандлага” сэдэвт сургалт, өдөрлөгийн хүрээнд 10 сарын 15- 10 сарын 21-ний өдрийг дуустал нийт 5 өдрийн 8 чиглэлийн сургалт, мэдээллийг давхардсан тоогоор 133 төвийн нийт албан хаагчид, резидент эмч нар болон 3 тасгийн 38 хэвтэн эмчлүүлэгч, үйлчлүүлэгч нарт хүргэн амжилттай зохион байгуулсан
2.2	Арьс судлалын нарийн мэргэжлийн эмч нар бэлтгэх	Арьс судлалын нарийн мэргэжлийн эмч бэлтгэгдсэн байна.	Бэлтгэгдсэн эмч нарын тоо				+	2024 онд арьс судлал үндсэн мэргэшлийн сургалтад 29 резидент суралцаж байна.
2.3	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтын багц цагийн бүрдүүлэлт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэг, лицензэд шаардлагатай кредит бүрдүүлэлт хийгдсэн байна	Багц цаг бүрдүүлэлтийн тайлан				+	6 удаагийн багц сургалт зохион байгуулснаас төвийн 87 эмч, сувилагч, резидентүүд давхардсан тоогоор хамрагдсан. Мөн энэхүү багц сургалтад гаднаас буюу 471 арьс харшлын эмч, дүүрэг, өрхийн эмч, сувилагч нар хот, аймаг, сумдаас хамрагдсан.

2.4	Эмч, эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээнд нийцсэн богино хугацааны тасралтгүй сургалтыг зохион байгуулах	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн мэдлэг, ур чадвар нэмэгдэнэ.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо				+	Төвийн хэмжээнд ХАБайдлын ажилтан, Ёс зүйн хороо, Хүний нөөцийн албанаас тус тус зохион байгуулсан сургалтуудад 130 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, резидентүүдийг хамруулсан. Мөн эмч нарын нэгдсэн “Журнал клуб” нь долоо хоног бүрийн лхагва гаригт мэргэжлийн болон анагаах ухааны бусад салбарын олон улсын сэтгүүлд хэвлэгдсэн шинжлэх ухааны өгүүлэл, эмнэлзүйн удирдамж, онолын мэдээлэл, практикт тохиолдсон эмнэлзүйн ховор тохиолдлын талаар танилцуулах ба оны 1 сард мэдээлэл хийх хуваарь гаргаж, баталсан хуваарийн дагуу сүүлийн 2 жилд шинэ мэдээлэл хийж хэвшсэн.
2.5	Өндөр хөгжилтэй оронд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулах, туршлага судлах	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд өндөр технологи, ур чадвар шаардсан тусламж, үйлчилгээг үзүүлэх чадвар дээшилнэ.	Сургалтын тайлан Гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо				+	10 эмч, 1 сургалтын арга зүйчийг өндөр хөгжилтэй орнуудад сургалтад хамруулсан.
2.6	Эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжлийн болон боловсролын зэрэг хамгаалахад дэмжлэгт орчин бүрдүүлэх	Ажилтны мэргэжлийн ур чадвар, боловсрол дээшилнэ	Тухайн жилд боловсролын болон мэргэжлийн зэрэг ахиулсан ажилтны тоо, хувь				+	1 эмч, 1 эмнэлгийн мэргэжилтэн ахлах зэрэг хамгаалсан ба цалинтай чөлөө олгосон.
2.7	Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварын үнэлгээ хийх	Мэргэшсэн ур чадвартай эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэгдсэн байна.	Эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг гаргасан тоо				+	Сургалтын хэрэгцээ чадавхыг тодорхойлох 6 асуумжтай асуулгыг 62 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс аван дүгнэлт нэгтгэлийг хийсэн.
2.8	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг эмнэл зүйн сургагч багшаар мэргэшүүлэх	Эмч, мэргэжилтнүүдийн ур, чадвар нэмэгдэж, эмнэлзүйн сургагч нарын нөөц бүрдэнэ.	Эмнэл зүйн сургагч багшийн тоо				+	2024 онд 2 сургагч багш тэтгэвэрт гарч, төвийн 2 эмч эмнэлзүйн сургагч багшийн сургалтад хамрагдсанаар нийт 12 эмч, 5 сувилагч эмнэлзүйн сургагч багшийг үнэмлэхтэй байна

Зорилт 3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах

3.1	Цалин хөлс, урамшууллыг Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу хэрэгжүүлэх	Ажилтны тогтвортой ажиллах боломж, сэтгэл ханамж нэмэгдэнэ	Цалин хөлсийн бүртгэл судалгаа				+	Засгийн газрын тогтоолын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу үндсэн уалин хөлсийг олгодог. Засгийн газрын тогтоолын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу улирал тутам гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурын дагуу 1-р улиралд 105, 2-р улирал 130, 3-р улирал 133, 4-р улиралд 135 эмч, сувилагч, эмнэлгийн ажилтанд урамшуулал олгосон.
3.2	Мөнгөн ба мөнгөн бус урамшууллын тогтолцоогоор ажлын гүйцэтгэлийг сайжруулах хөшүүрэг болгох	Ажилтны ажлын бүтээмж, идэвхи дээшилнэ.	Мөнгөн ба мөнгөн бус урамшуулал авсан ажилтны бүртгэл судалгаа				+	2024 оны шилдгүүд, сувилагч бүр судлаач онол практикийн хурлаа байр эзэлсэн, Шинэ санаа өдөрлөгийн байр эзэлсэн, ЭМЯ болон төрийн одон медалиар ажлаа үнэлүүлэн шагнагдсан төвийн нийт 40 ажилтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу 14,762,570 төгрөгийн мөнгөн шагнал олгосон.
3.3	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах	Эмнэлгийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах	Урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд хамрагдсан тоо				+	2024 онд АӨСҮТөвийн ажилчдыг эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт "БУНДАН ЗҮРХ" ОХИД,ЭМЭГТЭЙЧҮҮД,ХОСУУДЫН ЭМНЭЛЭГТЭЙ гэрээ хийн 2024.06.04-2024.06.07 хооронд үзлэг шинжилгээнд хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилчдын хувь Нийт хамрагдвал зохих 124 эмэгтэй ажилчдаас хамрагдсан нь 81 буюу 65.3% ажилтан байна. эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэхэд төвөөс 2,835,000 төгрөгийг зарцуулсан. • Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төв нь SAS лабораторитой гэрээ байгуулан 2024 оны 06 дугаар сард дархлаажуулалтад хамрагдсан ажилчдын судалгааг хийж дархлаа тогтцын шинжилгээнд нийт 79 эмч ажилчдыг хамрууллаа. Ажилчдын В вирусийн дархлаа тогтоц шалгахаар 2,100,000 төгрөгийг зарцуулсан. • Мөн эмнэлгийн нийт хамрагдвал зохих 134 эмч ажилчдаас В вирусийн эсрэг 3 тун вакцинд 132 эмч ажилчид бүрэн хамрагдсан байна. Хамрагдалтын хувь- 98,5% байна. • Татгалзсан 2 ажилтан байна. • Томуугийн дархлаажуулалтад нийт хамрагдвал зохих 134 ажилчдаас хамрагдсан 75 ажилтан хамрагдсан байна. Хамрагдалтын хувь -55,9% байна. • Улаанбурханы дархлаажуулалтад нийт хамрагдвал зохих 134 ажилчдаас хамрагдсан 67 ажилтан хамрагдсан байна. Хамрагдалтын хувь -50% байна. • 2024 оны 06 дугаар сард эмнэлгийн эмч ажилчдад В, С, гепатит, тэмбүү, ХДХВ халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан. Нийт хамрагдвал зохих 137 эмч ажилчдаас 117 эмч ажилчид хамрагдсан байна. Хамрагдалтын хувь- 85,4% байна. • Мөн эмнэлгийн резидент эмч нарыг В, С, гепатит, тэмбүү, ХДХВ, халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулаа. Нийт хамрагдвал зохих 29 резидент эмч нараас 16 резидент эмч хамрагдсан байна. Хамрагдалтын хувь- 55% байна.

3.4	Ажилтнуудын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, идэвхийг тогтмол сэргээхэд чиглэсэн ажил, мэргэжлийн болон ур чадварын уралдаан, тэмцээнийг тогтмол явуулах, урамшуулах, ажилтны эрүүл мэндийг дэмжих, эрүүлжүүлэх	Ажилтнуудын идэвхи дээшилж, найрсаг, эвсэг хамт олон байх нөхцөл бүрдэнэ.	Зохион байгуулагдсан үйл ажиллагааны тоо, тайлан				+	Сувилагч нар болон Эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн ур чадварын шалгалтыг сувилахуйн албанаас 2 жилд 1 удаа зохион байгуулдаг ба энэ жил амжилттай зохион байгуулан 1,2р байрыг цалингийн хувиар, 3р байрыг өргөмжлөлөөр шагнасан. Ажилтны эрүүл мэндэд анхааран долоо хоног бүрийн мягмар гаригт Иргэний бүртгэлийн спорт зааланд хамт олноороо сагс, волейбол тогтмол тоглодог.
3.5	Өрх толгойлсон, ганцаараа ажилладаг, амьдралын боломж багатай ажилтнуудыг дэмжлэгт удирдлагаар хангана.	Ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх	Мөнгөн ба мөнгөн бус дэмжлэг үзүүлсэн тоо				+	Ажилтны нийгмийн баталгааны хүрээнд ар гэрт нь гачигдал гарсан болон бусад төрлийн буцалтгүй тусламжийг нийт 13 ажилтанд 6,800,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон.
3.6	Амьдралын нөхцөлийн дэмжлэгт удирдлагаар хангана	Ажилтны тогтвортой ажиллах боломж, сэтгэл ханамж нэмэгдэнэ	Зээлд хамрагдсан ажилтны тоо				+	Хасбанк, Худалдаа хөгжлийн банкттай хамтран ажиллах гэрээнд төвийн албан хаагчдад ипотекийн зээлийн хүсэлтийг дараалалгүй болгох, цалингийн зээлийн хүүг зөвхөн төвийн албан хаагч нарт банкны хүүгээс 2%-аар бага нөхцөлөөр олгох зэрэг нөхцөл тусган ажиллаж байна. Цалингийн зээлд хамрагдсан 18, ипотекийн зээлд хамрагдсан 1 ажилтан байна.